



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 443

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад заасан нэр бүхий 4 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2016 оны 12 дугаар сарын 12-ний өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалтын алба /Д.Баттулга/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.АЛТАЙ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын
13-ны өдрийн 413 дугаар тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах
арга хэмжээ авагдах гишүүн үнэт цаасны компаниудын
нэрс**

1. “Бумбат-Алтай ҮЦК” ХХК
2. "Зэт Жи Би ҮЦК" ХХК
3. "Санар ҮЦК" ХХК
4. "Фронтинер ҮЦК" ХХК

---oOo---